

*“Монголын Хөрөнгийн бирж” ХК-ийн  
33Х-ийн 2004 оны 10 дугаар сарын 15-ны  
өдрийн 65 тоот тогтоолоор батлав.*

## **МХБ ХК-ИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

### **Нэг. НИЙТЛЭГ ЗҮЙЛ**

1.1. Монгол улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон Үнэт Цаасны Хороо, Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн /цаашид МХБ ХК гэх / дүрэм журам, бусад хууль тогтоомж, олон улсын бизнесийн эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэх явцад Брокер дилерийн компанийн /цаашид БДК гэх/ ажилтнуудын зан үйлийг тодорхойлж, ажлын байранд биеэ авч явах байдал, үйлчлүүлэгч, харилцагч, хөрөнгө оруулагчидтай харилцах зан үйлийн горимыг тогтооход энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2 Энэхүү дүрмийн "ажилтан" гэснийг гишүүн БДК-д, "мэрэгжилтэн" гэснийг МХБ ХК-д ажиллаж буй үнэт цаасны зах зээлд ажиллах мэрэгжлийн шаардлага хангасан, сонгон шалгаруулалтад орж, эрх авсан иргэн гэж ойлгоно. Энэ дүрмийн холбогдох заалтууд нь тухайн БДК-ний гэрээт ажил гүйцэтгэгчид болон зөвлөхүүдэд нэгэн адил хамаарна.

1.3 МХБ ХК нь ажилтанд менежер, дилер, арилжааны брокерийн эрх авах, БДК-иудад урамшуулал олгох, эрх цуцлах, шийтгэлийн арга хэмжээ авах болон тэдгээрийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргахдаа аливаа шалгуураар ялгаварлан гадуурхахгүй.

### **Хоёр. БДК-ИЙН АЖИЛТАНД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

2.1. Ажилтан нь үнэт цаасны зах зээлийн холбогдолтой хууль, дүрмийг хүндэтгэн дээдэлж, үйл ажиллагаандаа мөрдвөл зохих холбогдох журам, заавруудыг чанд дагаж мөрдөж ажиллана.

2.2. Ажилтан нь өөрийн бүхий л хүч чадварыг дайчлан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхийн төлөө болон түүний эрх ашгийн тулд ажиллана.

2.3. Ажилтан нь үнэт цаасны зах зээлийн нэр хүнд, ашиг сонирхлын эсрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

2.4. Ажилтан нь бусдыг яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, тахир дутуу болон оюуны хомсдолтой байдал, хуулиар хамгаалагдсан бусад шинж чанаруудаар ялгаварлан гадуурхахгүй.

2.5. Ажилтан нь үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой нууцад хамаарах мэдээллийг хамгаалж, нууцална.

2.6. Ажилтан нь үйлчлүүлэгчээс бэлэг, мөнгө, шагнал авах, өөрт ашигтай аливаа туслалцаа авахыг хориглоно.

2.7. Ажилтан нь ажил хэрэгтэй холбоотой аливаа асуудлаар хэдийд ч МХБ ХК болон Үнэт цаасны хороонд хандаж болно. Мөн сонирхлын аливаа зөрчилдөөнийг шийдвэрлүүлэхээр хандах эрхтэй.

2.8. Ажилтан нь үүрэгт ажлаа гүйцэтгэхдээ шударга үнэнч, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлана.

2.9. Ажилтан нь удирдлагын шийдвэрээр шаардлагатай мэдээ материалыг эрх бүхий байгууллага этгээдэд саадгүй гаргаж өгнө.

2.10. Ажилтан нь хоорондоо болон бусад байгууллага, хувь хүмүүс, үйлчлүүлэгчтэй харьцахдаа тэдгээрийн нэр хүндийг гутаан доромжлох, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, сэтгэл санааны болон аливаа зүй бус дарамт учруулахыг хориглоно.

2.11. Ажилтан нь БДК-д хандаж гаргасан байгууллага, иргэдийн хүсэлт, гомдол, мэдээлэлд анхааралтай хандаж шуурхай шийдвэрлэнэ.

2.12. Ажилтан нь зөвшөөрснөөс бусад газарт, түүнчлэн тамхи татдаггүй ажилтны дэргэд түүний зөвшөөрөлгүйгээр тамхи татахыг хориглоно.

2.13. Ажилтан нь ажлын байранд болон ажлын цагаар архи болон согтууруулах ундааны төрлийн зүйл хэрэглэхийг хориглоно.

2.14. Ажилтан нь үнэт цаасны арилжаанд оролцохдоо МХБ ХК-ны үнэт цаасны арилжааны журмын арилжааны дэг болон холбогдох журмаар тогтоосон дэг журмыг

мөрдөж ажиллах ба холбогдох ажилтан, мэргэжилтнүүдийн тавьсан шаардлагыг биелүүлнэ.

### **Гурав. КОМПАНИЙН БОЛОН ХУВИЙН НУУЦЫГ ХАМГААЛАХ**

3.1. Ажилтан нь МХБ ХК-ийн хяналт, шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, материалыг шалгахад аливаа саад учруулахгүй.

3.2. МХБ ХК нь дээрхи мэдээллийг албан бус зорилгоор ашиглах болон бусад задруулахыг хориглоно.

3.3. Ажилтан нь учир холбогдлыг ойлголгүйгээр байгууллагуудын болон харилцагчдын холбогдолтой мэдээллийг гадагш явуулах, бусдад задруулахыг хориглоно.

### **Дөрөв. ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХАНГАЛТ, ХЭРЭГЛЭЭ**

4.1. Ажилтныг ажил хэргээ хэвийн явуулахад зориулан МХБ ХК-иас олгосон материал, техник, хэрэгсэл, программ хангамж, харилцаа холбооны техник хэрэгслэлд ариг гамтай хандаж, үр бүтээлтэй ашиглана.

4.2. Эдгээрийг ажилтан нь ажлын бус, хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.

4.3. Ажилтан компьютерт вирус тарж болзошгүй талаар мэдээлэл авсан даруйд /нийтэд мэдээлэн түгшээлгүйгээр/ МХБ ХК-ны албаны захирал болон бусад холбогдох албан тушаалтанд мэдэгдэнэ.

4.4. Ажилтан нь нууц үг, код зэргээ зөвшөөрөгдсөн ажилтнаас бусдад өгөх, ил задгай тавих зэргээр тараахгүй байвал зохино.

4.5. МХБ ХК нь ажилтныг техник хэрэгсэл, технологийг зохих журмын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах зорилгоор түүний компьютерийн сүлжээнд нэвтрэх эрхтэй.

4.6. Ажилтан нь хувийн чанартай болон бусдын нэр хүндийг гутаасан болон бусад хориглосон мэдээллийг сүлжээнд оруулсан нөхцөлд мэдсэн даруйд устгах, бусдад тараалгүйгээр МХБ ХК-ны захиргаанд мэдэгдэх үүрэгтэй.

4.7. Ажилтан нь ажлын байранд зөв зохистой, цэвэр үзэмжтэй хувцаслана.

## **Тав. ХАРИУЦЛАГА**

5.1. Ажилтан нь түүний аливаа үйл ажиллагаа нь үнэт цаасны зах зээл, МХБ ХК болон түүний гишүүн БДК-ны нэр хүндтэй ямагт холбоотой гэдгийг санаж, ажлын бус нөхцөлд ч тохируулан биеэ авч явах, энэхүү дүрмийг дагаж мөрдөх нь зүйтэй.

5.2. Энэхүү дүрмийг зөрчсөн нөхцөлд үнэт цаасны зах зээлийн холбогдох хууль, дүрэм, журам, гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээ авна.